

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР**

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 26/01

Улаанбаатар хот

**Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг
нэмэгдүүлэх саналыг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13 болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан эцнээ санал хураалтын үр дүн, Тооллогын комиссын тайланг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг дараах нөхцөл бүхий хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх саналыг баталсугай.

Гэрээ байгуулах тал	“АНД Системс” ХХК
Хоёрдогч өглөгийн нийт хэмжээ	10,740,000,000 (арван тэрбум долоон зуун дөчин сая)
Хугацаа	5 (тав) жил
Хүүгийн төлбөр төлөх хугацаа	6 (зургаа) сар тутам
Эргэн төлөх нөхцөл	Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, компани татан буугдсан, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хугацаанаас өмнө эргэн төлөхгүй.
Хувьцаанд хөрвөх нөхцөл	Хугацааны эцэст ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус хоёрдогч өглөгийг компанийн хувьцаанд хөрвүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Хэрвээ шилжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд шилжүүлэх нөхцөлийг тогтооно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хоёрдогч өглөгийг Компанийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд хугацааны эцэст эргэн төлнө.

2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан нөхцөлийн дагуу Хоёрдогч өглөгийн хүүг тогтоож, гэрээ байгуулах болон эдгээртэй холбогдон үүсэх бусад асуудлаар холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчийн хурлын хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Энэхүү шийдвэртэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хороонд холбогдох мэдэгдэл хүргүүлж, зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг баталгаажуулах, бүрдүүлж өгөх, эдгээртэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

4. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

О.БОЛДБААТАР

